



ДОРНЫН ХОС ТРАНС ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ХАТАНБУЛАГ СУМЫН 3-Р БАГТ БАЙРЛАХ ГААЛИЙН ХЯНАЛТЫН БҮС  
ТӨСЛИЙН 2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨ



Улаанбаатар хот  
2024 он

## АГУУЛГА

### ОРШИЛ IV

<b>БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....</b>	<b>1-1</b>
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ .....	1-1
1.2 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	1-1
1.2.1 Төслийн зорилго .....	1-1
1.2.2 Төслийн байршил .....	1-1
1.2.3 Төслийн барилга байгууламжууд.....	1-2
1.2.4 Төслийн хүчин чадал .....	1-3
1.3 ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ.....	1-3
1.4 ХОГ ХАЯГДАЛ .....	1-3
<b>БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОЙМ .....</b>	<b>2-1</b>
<b>БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ .....</b>	<b>3-1</b>
3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ .....	3-1
3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ .....	3-1
3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ .....	3-1
3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ .....	3-1
3.5 Нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	3-2
<b>БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....</b>	<b>4-1</b>
4.1 ГОЛ ЗОРИЛТ.....	4-1
4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ.....	4-1
4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	4-1
4.4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	4-6
4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	4-7
4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	4-8
4.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	4-9
4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР .....	4-10
4.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ .....	a
4.10 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ .....	b

## ДҮГНЭЛТ С

### Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1.Төслийн талбайд ажиллах хүч, орон тоо.....	1-3
Хүснэгт 1-2. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх боломжтой аюултай хог хаягдлын жагсаалт.....	1-4
Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй .....	4-1
Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	4-2
Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө .....	4-6
Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	4-8

Хүснэгт 4-5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	4-11
Хүснэгт 4-6. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө .....	a
Хүснэгт 4-7. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь .....	b
<b>Зургийн жагсаалт</b>	
Зураг 1-1. Төслийн байршил .....	1-1
Зураг 1-2. Төслийн талбайн харагдах орчин .....	1-2

## ОРШИЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрх зүйн баримт бичиг юм.

Дорнын хос транс ХХК-ийн 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Байгаль орчны тухай багц хуулиуд болон тэдгээртэй холбогдон гарсан дүрэм, журам, стандартууд, БОАЖЯ-ны 2024.02.19 өдрийн 12/790 тоот байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт, 2024 онд Баялаг Эко ХХК-ийн боловсруулан батлуулсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон БОАЖС-ын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу боловсруулав.

Энэхүү төлөвлөгөөгөөр Гаалийн хяналтын бүс төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийг тогтоосон бөгөөд 2024 оны БОМТ нь 2024 онд батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн эхний жилийн БОМТ юм.

## БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр:	Гаалийн хяналтын бүс байгуулах төсөл
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	Дорнын хос транс ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	0611008016
Регистрийн дугаар:	3319164
Утас:	+976 99998398, +976 88096249
Хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Сүмбэр таур, 13-5 тоот
Цахим шуудан:	<a href="mailto:dorniinkhostrans1@gmail.com">dorniinkhostrans1@gmail.com</a>


### 1.2 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

#### 1.2.1 Төслийн зорилго

Дорнын хос транс ХХК нь Дорноговь аймгийн Хатанбулаг суманд өөрийн эзэмшлийн 10 га талбайд Гаалийн хяналтын бүс байгуулж, өөрийн Гаалийн хяналтын бүсээр дамжуулан улс хоорондын ачаа тээвэрлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах зорилготой.

#### 1.2.2 Төслийн байршил

Төслийн талбай нь Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Агаруут багт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос 750 км, Дорноговь аймгийн төв Сайншандаас 300 км, Хатанбулаг сумын төвөөс 100 км-т Ханги боомт орчим байрлана.



Зураг 1-1. Төслийн байршил



Зураг 1-2. Төслийн талбайн харагдах орчин

### 1.2.3 Төслийн барилга байгууламжууд

Дорнын хос транс ХХК-ийн Гаалийн хяналтын бүс байгуулах төсөл нь барилга байгууламжийн хувьд дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Гаалийн хяналтын бүсийн хашаа
- Авто пүү
- Хяналтын байр
- Харуулын байр
- Гаалийн хяналтын байцаагч болон ажилчдын байр оффис
- Ажилчдын чөлөөт цаг өнгөрөөх талбай
- Нүүрс ачиж буулгах талбай



Зураг 1-1. Гаалийн хяналтын бүсийн төлөвлөлт

Гаалийн хяналтын бүс байгуулах 10 га талбайн 3 га-д ажилчдын кемп, 2 га-д авто зогсоол байгуулж үлдсэн 5 га талбайд нүүрс ачиж буулгах талбай байгуулна.

#### 1.2.4 Төслийн хүчин чадал

Гаалийн хяналтын бүс байгуулах төсөл нь жилд 8 сая.тн нүүрс буулгах хүчин чадалтай бөгөөд HANVAN G7 маркийн нийт 20 тээврийн хэрэгсэлтэй ба 1 машин дунджаар 137 тн нүүрс тээвэрлэх хүчин чадалтай.

Төслийн талбайд нийт 12 хүн ажиллахаар төлөвлөж байна.Төслийн талбайд нийт ажиллах хүч 16 хүний бүрэлдэхүүнтэй байна. Төслийн талбайд ажиллах хүчийг Хүснэгт 1-1-д тусгав.

Хүснэгт 1-1.Төслийн талбайд ажиллах хүч, орон тоо

№	Ажиллах хүч	Орон тоо
1.	Талбайн эрхлэгч	1
2.	Талбайн зохион байгуулагч	2
3.	Гаалийн мэдүүлэгч	1
4.	Гаалийн бүрдүүлэлт хийх мэргэжилтэн	1
5.	Пүүний мэдүүлэгч	2
6.	Бүтээлэг бүтээгч	1
7.	Хүний нөөцийн менежер	1
8.	Нягтлан бодогч	1
9.	ХАБЭА-ын ажилтан	2
10.	Тогооч	1
11.	Аж ахуйн нярав	1
12.	Харуул	2
<b>Нийт</b>		<b>16</b>

Төслийн талбайд нийт 12 хүн гаалийн ерөнхий газрын цагийн хуваарийн дагуу жилийн 4 улирал ажиллана.

#### 1.3 ТӨСЛИЙН ДЭД БҮТЭЦ

**Цахилгаан хангамж :** Ханги боомт нь БНХАУ-с 110 кВт-ын цахилгаан эрчим хүчээр хангагдах ба төслийн цахилгааны хэрэглээг КТПН-30/108/0.4 кВт чадлын дэд станцаас хангахаар төлөвлөж байна.

**Усан хангамж:** Төсөл хэрэгжүүлэгч Дорнын хос транс ХХК нь ажилчдын үнд ахуйн усыг зөөврөөр хангахаар төлөвлөж байна.

#### 1.4 ХОГ ХАЯГДАЛ

**Ахуйн хог хаягдал.** Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын ахуйн гаралтай хог хаягдал гарна. Нийт 12 хүнээс нэг ээлжид ажиллах хүний тоогоор буюу 12 хүнээр тооцож, нэг хүн өдөрт 0.4 кг хоногт нийт 12 ажилтнаас 4.8 кг, жилд ойролцоогоор 1,752 кг (1.7 тн) ахуйн хаягдал хатуу хог хаягдал гарахаар байна. Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хадгалан сумын эрх бүхий байгууллагад гэрээгээр тээвэрлүүлнэ.

**Шингэн хаягдал.** Ажилчдын ахуйн хэрэглээ болон цайны газраас хоногт ахуйн бохир шингэн хаягдал гарна. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар “Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм”-ын 12-р хавсралтын “Худаг, булаг зэрэг уснаас зөөврөөр хангагддаг гэр хороолол” төрлөөр авч үзэн нэг хүний усны хэрэглээний нормын дагуу нэг хүн хоногт дунджаар 20 литр ус хэрэглэнэ гэж тооцоолоход хоногт 12 хүний үнд ахуйн хэрэгцээнд хоногт 0.24 м<sup>3</sup> (жилд 87.6 м<sup>3</sup>) ус хэрэглэхээр байна. Үүний 70 %-ийг ахуйн шингэн хаягдал болно

гэж тооцвол хоногт дунджаар 0.168 м<sup>3</sup> жилд ойролцоогоор 61.32 м<sup>3</sup> шингэн хаягдал гарахаар байна.

### Аюултай хог хаягдал

Төслийн үйл ажиллагааны үед үүсэж болзошгүй аюултай хог хаягдлыг Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт “Аюултай хог хаягдлын жагсаалт”-аас шүүн доорх хүснэгтэд тусгав. БОАЖС-ын 2017 оны А/349 тоот тушаалаар батлагдсан “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл” -д заасны дагуу “Хяналттай хог хаягдал”-ын аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүний хэмжээ тус тушаалын хавсралтад заасан босго түвшинтэй тэнцүү болон түүнээс их хэмжээгээр агуулж байвал аюултай хог хаягдал гэж үзнэ. Энэ тохиолдолд аюултай хог хаягдлын журмаар зохицуулагдана.

*Хүснэгт 1-2. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх боломжтой аюултай хог хаягдлын жагсаалт*

Хог хаягдлын бүлэг, код	Хог хаягдлын дэд бүлэг, код	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл	
13. Хаягдал тос ба шингэн түлш (хүнсний тос, Д ба Л бүлгийн тос хамаарахгүй)	13.05. Шингэн түлшний хаягдал	13 05 01*	Түлшний тос, дизель	А	
		13 05 02*	Бензин	А	
		13 05 03*	Бусад түлш (холимог түлш орно)	А	
15. Сав баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15.01. Сав баглаа боодол (ангилян ялгасан ахуйн сав баглаа боодлын хаягдал орно.)	15.01.09*	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав баглаа боодол	А	
		15.02. Шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	15.02.01*	Хортой бодисоор бохирдсон шингээгч, бохир алчуур материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас	Х
	16.06. Батерей, аккумулятор	16.06.02*	Никель – Кадмийн батерей	А	
		16.06.03*	Мөнгөн ус агуулсан батерей	А	

**Тайлбар:** “А” Аюултай, “Х” Хяналттай хог хаягдал



## БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОЙМ

**Физик газарзүйн нөхцөл.** Төслийн талбай нь физик газарзүйн нөхцөлөөр Дорнод говийн мужид багтана. Энэ муж нь Мандал овоо-Хулдын ухаа гүвээт тал, Мандал-овоо- Өлзийтийн цав толгод, Дэлгэрэх-Алтанширээгийн тал, Хатанбулаг-Хөвсгөлийн нам уулс, Галба-Шанхын уулс гэсэн үндсэн 5 дэд мужид хуваагдана. Нийт 233,468.2 км<sup>2</sup> буюу нийт нутаг дэвсгэрийн 15 хувийг эзэлнэ.

**Цаг уур, уур амьсгал.** Дорноговь аймаг уур амьсгалын хувьд хуурайдуу сэрүүвтэр, хуурай дулаавтар, мужид багтана. Манай орны бусад нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Агаарын температурын үнэмлэхүй их утга 33.6°C, өвөлдөө хүйтэн боловч зундаа аагим халуун болдог байна. Төслийн талбай орчимд зуны сар болох 7-р сарын дундаж температур 23.1°C, жилийн хамгийн хүйтэн 1-р сарын дундаж агаарын температур -20.7 °C байдаг. Жилийн хамгийн их хур тунадастай сар бол 8-р сар ба тухайн сард 26.9 мм хур тунадас ордог. Нийт жилийн хугацаанд дунджаар 103.2 мм хур тунадас ордог. Тухайн орон нутгийн хотгор гүдгэр, газрын гадаргын шинж зэргээс хамааран улирлын шинж газар бүр харилцан адилгүй байдаг.

**Геологи, геоморфологи.** Энэ мужийн нутаг дэвсгэр нь платформын хөгжлийн үе шат, тэр дундаа Говийн плитийн хөгжилтэй ихээхэн холбоотой. Говийн плит нь атираат суурьтай ба түүний нам дор хэсгүүд нь 700-800 м хүртэл гүнд шургаж эдгээрт харгалзах хотос хонхор нь дээд цэрдийн ба палеогений насны эх газрын хурдсаар дүүргэгдсэн байдаг. Дээд цөрд, палеоген насны хурдас нь хэвтээ эсвэл хэвтээд дөхүү чиглэлд тархсан байдаг байна.

**Гадаргын ус болон газрын доорх ус.** Дорноговь аймаг нь Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамаарна. Ай савыг дотор нь хамрагдах голын сав газарт хуваах бөгөөд төслийн талбай нь Галба-Өөш-Долоодын сав газарт хамаарна. Төв Азийн гадагш урсгалгүй ай сав нь Монгол орны баруун, баруун өмнөд ба өмнөд хэсгийг хамрах бөгөөд Хангайн өвөр ба баруун, Хэнтийн өмнөд хажуу, Монгол Алтайгаас эх авах голууд, өмнөд хэсгийн гол горхиуд болон том нууруудыг хамарна. Ай савын хүрээнд Хар нуур-Ховд, Булган, Үенч-Бодонч, Хяргас нуур-Завхан, Увс нуур-Тэс, Онги, Таац, Бөөн цагаан нуур-Байдраг, Орог нуур-Түй, Хүйсийн говь-Цэцэг нуур, Умард говийн гүвээт-Халхын дундад тал (Жаргалант гол), Галба-Өөш-Долоодын говь (Баруун, Дунд, Баянгийн булаг), Алтайн Өвөр говь (Сагсай гол, Баян гол) гэсэн 13 сав газар болгож ангилсан байна.

**Хөрсөн бүрхэвч.** Төслийн нийт талбай нь 10 га бөгөөд талбайн хүрээнд нам ухаа гүвээ болон тэдгээрийн хоорондох хөндий бүхий д.т.д 1068-1078 м өндөртэй газарт байрлана. Судалгаанд хамрагдсан талбайд Монгол орны хөрсний ангиллаар Бор хөрсний дэд хэв шинжид багтах сайргархаг ба элсэн хэв шинжийн хөрснүүд дангаараа болон бүрдэл байдлаар тархсан байна. Эдгээр хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин маш бага, шимт үе давхарга нь нимгэн (0-40 см), хэврэг өрмөнцөр болон үйрмэг бүтэцтэй, механик нөлөөлөлд тэсвэргүй, байгалийн аясаараа нөхөн сэргэх чадамж маш сул байдаг онцлогтой. Мөн чулуурхаг, том ширхэгтэй элсний агууламж өндөртэй байна. Хөрсний үе давхарга нь ихэвчлэн Vca-BCca-Cca гэсэн дараалалтай, хөрсний дээд үе давхаргын (0-30 см) ялзмагийн агууламж 0.35-0.6%, бүх үе давхарга карбонатжилттай, урвалын орчин 8.7-8.9 буюу хүчтэй шүлтлэг, хялбар уусах давсжилт нь сайргархаг Бор хөрсний өнгөн үе давхаргад их (2.33 dS/m) агууламжтай, бусад хөрсөнд маш бага буюу 0.11-1.16 dS/m байна. Хүнд металлын шинжилгээний үр дүнгээс үзэхэд өнгөн хөрсөн дэх Cd, Mo, Sn гэсэн металлууд маш бага буюу бараг илрээгүй, бусад металлууд стандартын хүлцэх агууламжаас хэтрээгүй буюу хэвийн түвшинд байна.

**Ургамлын аймаг.** Төслийн талбай нь ургамал газарзүйн тойргоор Алашаан говийн цөлийн тойрогт хамаардаг (Өлзийхутаг, 1989). Алашаа говийн цөлийн тойрог нь Тост уулын өврөөс эхлээд зүүн тийш Борзон говь, Галбын говийг дамжин Сулинхээр хүртэлх нарийн зурвас газрыг багтаана. Алашаа говьд тойргийн хойд хэсгээс урагшлахад намсдаг хэвгий гадаргатай. Газрын гадаргын

хувьд бэсрэг уулс, хотгор хотос, тойром, цав толгод, ухаа гүвээ ээлжлэн солигдохын зэрэгцээ умардаас өмнийг чиглэсэн хуурай сайр олонтой юм. Бор бударгана, багалуур, хойрго, хотир, шар мод, боролзой, улаан бударгана, заг хармаг зонхилон ургадаг. Элсэнцэр цөлөөс гадна чулуурхаг цөл нэлээд их тааралдана. Марцлаг элстэй хотгороор нь сибирь хармаг оролцсон загт цөлтэй. Манхан элстэй газраар нь *Hedysarum fruticosum*, *H.scoparium*, *Atriphaxis frutescens*, *Caragana bungei*, *C. Korshinskyi* зэрэг сөөглөг ургамал тохиолдоно.

**Амьтны аймаг.** Төслийн талбай орчим нь Монгол орны амьтны аймгийн мужлалаар Хойд говийн тойрогт хамаарна (Банников,1954). Говийн амьтны аймгийн үүсэл гарлын хувьд эртний бөгөөд Төв Азийн амьтны аймгийн үүслийн үндсэн голомтын нэг гэж тооцогддог. Энд орогномол ба цөлийн нөхцөлд амьдран зохицох илэрхий шинж тэмдгүүдийг агуулсан амьтад оршдогоороо бусад тойргуудаас ялгаатай (Болд,1967.Дуламцэрэн,1973). Хээрийн судалгаанд төслийн талбайд болон түүний ойр орчмоос хөхтөн амьтад болох хулан, цагаан зээр, хар сүүлт, морин чичүүл зэрэг амьтдыг бүртгэсэн. Мөн хээрийн судалгааны явцад 7 зүйлийн 54 шувууг бүртгэжээ. Ханги мандал улсын хилийн боомт, түүний орчмын бүс нутагт өмнө хийгдсэн судалгааны ажлын тайлангуудад тусгаснаар 2 салбар баг, 5 овог, 7 төрөлд хамаарах 7 зүйлийн мөлхөгчид тохиолдох боломжтойг холбогдох эх сурвалжаас шүүж гаргасан.

#### Нийгэм эдийн засгийн төлөв байдал

**Дорноговь аймаг:** Тус аймагт 2022 оны жилийн эцсийн байдлаар 21,265 өрхийн 71,812 хүн оршин сууж байна. Дорноговь аймгийн өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 0.7 хувиар өссөн бол хүн амын тоо 0.4 хувиар буурсан байна. 2022 оны жилийн эцсийн малын тооллогоор 5,886 малтай өрх, 7,293 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 57 малчин багассан бол 62 малтай өрхөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 2,909,700 мал тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 202,900 толгой мал буюу 6.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2022 оны байдлаар нийт мал сүргийн 6.9 хувийг адуун сүрэг, 4.6 хувийг үхэр сүрэг, 1.8 хувийг тэмээн сүрэг, 42.8 хувийг хонин сүрэг, 43.9 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

**Хатанбулаг:** Тус суманд 2022 оны жилийн эцсийн байдлаар 1,013 өрхийн 2,853 хүн оршин сууж байна. Хатанбулаг сумын өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 5.1 хувиар, хүн амын тоо 1.1 хувиар тус тус буурсан байна. 2022 оны жилийн эцсийн малын тооллогоор Хатанбулаг сум нь 644 малтай өрх, 853 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 12 малчин, 2 малтай өрхөөр буурсан үзүүлэлттэй байна. 2022 онд нийт мал сүргийн 6.1 хувийг адуун сүрэг, 4.5 хувийг үхэр сүрэг, 3 хувийг тэмээн сүрэг, 31.3 хувийг хонин сүрэг, 55.1 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

**Агаруут баг:** 2022 оны жилийн эцсийн байдлаар 183 өрхийн 521 хүн оршин сууж байна. Агаруут багийн өрхийн тоо өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өсөж, хүн амын тоо 3.3 хувиар буурсан байна. 2022 оны жилийн эцсийн малын тооллогоор Агаруут баг нь 162 малтай өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байна. Тус багийн хэмжээнд 2022 онд нийт 103,620 толгой мал тоологдсоноос мал сүргийн 6.7 хувийг адуу сүрэг, 4.8 хувийг үхэр сүрэг, 1.2 хувийг тэмээн сүрэг, 30.4 хувийг хонин сүрэг, 56.9 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

**Газар ашиглалт:** Газрын нэгдмэл сан нь Монгол улсын газрын тухай хуулийн 10-р зүйлд заасны дагуу үндсэн 6 санд хуваагдана. Дорноговь аймгийн газрын нэгдмэл сангийн ангиллаар хөдөө аж ахуйн эдэлбэр газар 9,515 га, хот тосгон бусад суурин газар 187.4 га, зам шугам сүлжээний газар 62.7 га, ойн сан бүхий газар 158.6 га, усан сан бүхий газар 27.6 га, улсын тусгай хэрэгцээний газар 995.9 га талбайг тус тус эзэлж байна.

#### Хөдөө аж ахуй:

**Дорноговь аймаг.** Тус аймагт 2023 оны жилийн эцсийн малын тооллогоор 5,783 малтай өрх, 7,134 малчин мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх онтой харьцуулахад 159 малчин, 103 малтай өрхөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн хэмжээнд 2,294.82 мянган мал

тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 614.88 мянган толгой мал буюу 21.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2023 оны байдлаар нийт мал сүргийн 7.5 хувийг адуун сүрэг, 4.7 хувийг үхэр сүрэг, 2.4 хувийг тэмээн сүрэг, 43.5 хувийг хонин сүрэг, 41.9 хувийг ямаан сүрэг эзэлж байна.

Дээрх графикаас харахад 2023 онд малын тоо өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Тухайлбал, адуун сүрэг 171.71 мян толгой болж өмнөх онтой харьцуулахад 15.1 хувиар, үхэр сүрэг 108.08 мян толгой болж өмнөх онтой харьцуулахад 17.8 хувиар, хонин сүрэг 997.72 болж өмнөх онтой харьцуулахад 19.8 хувиар, ямаан сүрэг 962.77 толгой болж өмнөх оноос 24.6 хувиар тус тус буурсан бол тэмээн сүрэг 54.54 мян толгой болж өмнөх онтой харьцуулахад 3.5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хатанбулаг сум. 2023 оны байдлаар 627 малтай өрх, 500 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20 малчин өрх, 17 малтай өрхөөр тус тус буурсан үзүүлэлттэй байна. Сумын хэмжээнд 229,420 мал тоологдсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 93,540 толгой мал буюу 28.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт мал сүргийн 7.6 хувийг адуун сүрэг, 5.4 хувийг үхэр сүрэг, 4.5 хувийг тэмээн сүрэг, 32.1 хувийг хонин сүрэг, 50.4 хувийг ямаан сүрэг эзэлж байна. 2023 онд малын тоо өмнөх оны бүх төрөл дээр өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, адуун сүрэг 17,331 толгой болж өмнөх онтой харьцуулахад 14.6 хувиар, үхэр сүрэг 12,280 толгой болж өмнөх онтой харьцуулахад 21.7 хувиар, хонин сүрэг 73,463 болж өмнөх онтой харьцуулахад 29.1 хувиар, ямаан сүрэг 115,827 толгой болж өмнөх оноос 33.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин тэмээн сүрэг 10,516 толгой болж өмнөх онтой харьцуулахад 3.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

3-р баг. 2023 оны байдлаар 159 малтай өрх, 140 малчин өрх мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 малтай өрх, 10 малчин өрхөөр тус тус буурсан байна. Багийн хэмжээнд 2023 оны байдлаар 72,955 мал тоологдсон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30,667 толгой мал буюу 29.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт мал сүргийн 8.3 хувийг адуун сүрэг, 5.6 хувийг үхэр сүрэг, 1.6 хувийг тэмээн сүрэг, 31.4 хувийг хонин сүрэг, 53.1 хувийг ямаан сүрэг эзэлж байна. Тухайлбал, адуун сүрэг 6,036 толгой болж өмнөх онтой харьцуулахад 12.3 хувиар, үхэр сүрэг 4,078 толгой болж өмнөх онтой харьцуулахад 21.1 хувиар, хонин сүрэг 22,873 болж өмнөх онтой харьцуулахад 29.7 хувиар, ямаан сүрэг 38,808 толгой болж өмнөх оноос 32.9 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин тэмээн сүрэг 1,160 толгой болж өмнөх онтой харьцуулахад 0.5 хувиар өссөн байна.

### **Эрүүл мэнд:**

Тус аймгийн хэмжээнд нийт 76 эмнэлэг, 93 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд эмнэлгийн орны тоо 550 байна. Мөн аймгийн хэмжээнд эрүүл мэндийн салбарт 21 удирдах ажилтан, 259 их эмч, 23 эх баригч, 44 бага эмч, 46 багийн эмч, 261 сувилагч, 50 эм зүйч, 36 лаборант, 6 гэрлийн техникч, 75 эм найруулагч, бусад 11 ажилтан ажиллаж байна. Дорноговь аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар 20,801 хүн хэвтэн эмчлүүлсэн бөгөөд нэг эмчид 278 өвчтөн, нэг сувилагчид 369 өвчтөн тус тус ноогдож байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 08 сарын байдлаар нийт 735 эх амаржсан нь өмнөх оны мөн үеэс төрөлт 41 тохиолдлоор буурсан.

### Нийт төрсөн хүүхдийн:

- 48.9% нь эрэгтэй
- 51.1% нь эмэгтэй
- 3.0% нь 2500 граммаас доош бага жинтэй төрсөн.

2023 оны эхний 08 сард нийт 933 эхчүүдийг жирэмсний хяналтад авснаас жирэмсний эрт үеийн хяналт 90.9% болж өмнөх оны мөн үеэс 0.5%-р буурч, хожуу үеийн хяналт 9.1% болж өмнөх оны мөн үеэс 0.5%-р өссөн.

### БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОЙМ

#### 3.1 АГААРЫН ЧАНАРТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Төслийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд амрах байр, авто зогсоол, нүүрс ачиж буулгах талбай зэргийг байгуулах ба барилга угсралтын газар шорооны ажлын үед нийт тоос (TSP) 1259.56 кг,  $PM_{10}$  том ширхэгт тоос 377.86 кг,  $PM_{2.5}$  нарийн ширхэгт тоос 37.78 кг тоос тоосонцор үүснэ.
- Нүүрс ачих, буулгах болон тээвэрлэх үйл ажиллагаанаас жилд дунджаар үүсэх тоосны хэмжээг “Агаар бохирдуулагчдын тооллого хийх аргачлал”-ын дагуу тооцож үзэхэд жилд дунджаар дараах хэмжээгээр үүсэж агаарын бохирдол үүсгэхээр байна. Үүнд:
  - Нүүрс ачих үйл ажиллагаагаар нийт тоос (TSP) 343.12 кг, том ширхэгт тоос  $PM_{10}$  48.48 кг, нарийн ширхэгт тоос  $PM_{2.5}$  16.16 кг
  - Нүүрс буулгах үйл ажиллагаанаас жилд дунджаар 313.29 кг нийт тоос (TSP), 37.3 кг  $PM_{10}$ , 12.43 кг  $PM_{2.5}$
  - Нүүрс тээврийн замаар өдөрт 20 орчим тээврийн хэрэгслээр ачаа тээвэрлэнэ жилд 497.94 тн нийт тоос (TSP), 165.31 тн  $PM_{10}$ , 16.53 тн  $PM_{2.5}$
  - Нүүрс овоолгын талбайгаас жилд дунджаар 401.5 кг нийт тоос, 205 кг  $PM_{10}$ , 40 тн  $PM_{2.5}$
- Дээрх хэмжээгээр үүсэж болзошгүй тоос, тоосонцруудыг бууруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас ялгарах тоосны тархалт стандартаас давах хэсгийн агууламжуудыг загварчлалын аргаар тооцоолж үр дүнг Монгол улсын гадаад орчны агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага болох MNS 4585:2016 стандартын жилийн дундаж хүлцэх хэмжээтэй харьцуулав үзвэл:
  - Нийт тоосны тархалт стандартаас давах хэсгийн агууламж  $428 \text{ мкг/м}^3$  буюу стандартын хүлцэх хэмжээнээс 4.3 дахин
  - $PM_{10}$  тоосонцрын агууламж  $200 \text{ мкг/м}^3$  буюу жилийн дундаж хүлцэх хэмжээ  $50 \text{ мкг/м}^3$  агууламжаас 14 дахин давж орчны агууламжийг тус тус нэмэгдүүлэхээр байна.

#### 3.2 ГАЗРЫН ГАДАРГА, ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Барилга байгууламж барих, нүүрс буулгах талбай бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд 10 га талбайн хөрс хуулагдаж, хөрсөн бүрхэвч эвдрэлд өртөх
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч талхлагдах
- Ил задгай хог хаягдал хаясан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдох
- Ажилчдын ахуйн шингэн хаягдлыг шууд хөрсөнд зайлуулсан тохиолдолд хөрсөн бүрхэвч бохирдож болзошгүй.

#### 3.3 УСАН ОРЧИНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Унд ахуйд хоногт  $0.24 \text{ м}^3$  (жилд  $87.6 \text{ м}^3$ ) ус хэрэглэх
- Ажилчдын ахуйн шингэн хаягдлыг шууд хөрсөнд зайлуулсан тохиолдолд усан орчин бохирдох

#### 3.4 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Төсөл хэрэгжих хугацаанд 10 га талбайн шимт хөрсийг хуулснаар ургамлан нөмрөг устаж, хөрсөнд амьдрагч микро организм, шавж устах, жижиг мэрэгчдийн амьдрах орчин алдагдах
- Нүүрс тээвэрлэлтийн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоосжилтын нөлөөгөөр замын хажуугийн ургамлан нөмрөгийн физиологийн процесс алдагдах

- Төслийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс зэрлэг амьтад дайжих, үргэх

### 3.5 НИЙГЭМ ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

- Төсөл хэрэгжих сум орон нутагт ажлын байр нэмэгдэх
- Орон нутгийн дэд бүтцийн салбар, нийтийн аж ахуй, нийгмийн үйлчилгээ зэргийг сайжруулахад орон нутагтай хамтран ажиллах, хөрөнгө оруулалтаар дамжуулан эергээр нөлөөлөх
- Татвар болон бусад заавал төлөх төлбөр хураамжаар дамжуулан улс, аймаг болон суманд татвар хураамж төвлөрүүлэх, улмаар төсвийн орлого нэмэгдэх
- Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг Хатанбулаг сумаас хангаснаар орон нутгийн эдийн засгийн эргэлтэд эергээр нөлөөлөх

## БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

### 4.1 ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулав.

### 4.2 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Дорнын хос транс ХХК-ийн Гаалийн хяналтын бүс төслийн 2024 оны БОМТ-г Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2019 оны 10-дүгээр сарын 29-ны өдрийн А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3-р хэсэг болох тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах агуулгад заасны дагуу хийж гүйцэтгэсэн ба 2024 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд **17,745,000** төгрөг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4-1. 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (₮)	
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,100,000	
2.	Байгаль орчныг Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,855,000	
3.	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,400,000
4.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	800,000	
5.	Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,000,000	
6.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4,590,000
<b>Нийт зардал</b>		<b>17,745,000</b>	

### 4.3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанар, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг зэрэг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр нь авч үзэн 2024 оны БОМТ-ний сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан Хүснэгт 4-2-д тусгав.

Хүснэгт 4-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	арилгах, Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая төг ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
<b>Агаарын чанар</b>									
1.	Талбайд нүүрс ачиж, буулгаж, хадгалах үед агаарт тоосжилт үүсэх	Тээвэрлэлтийн үед хурдны хязгаарт хяналт тавих (ачих, буулгах хэсэгт 20 км/ц, технологийн замд 40 км/ц байх г.м) тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах	Төслийн талбай	5 тэмдэг	ш		0.1	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	<b>MNS ISO4227-2002</b> Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
2.		Тоосжилтыг бууруулах зорилгоор нүүрс ачиж буулгах талбайг тойруулан салхинаас хамгаалах торон хашааг байгуулах, эвдрэл гэмтэл үүссэн тохиолдолд тухай бүрд засварлах	Төслийн талбай	12-15 м өндөр	м <sup>2</sup>		ХОЗ*	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	<b>MNS 4585:2016</b> Агаарын чанар техникийн ерөнхий шаардлага
3.	Хүнд даацын машин механизмын хөдөлгөөнөөр агаарт тоосжилт, SOx, NOx зэрэг бодисууд ялгарах	Ашиглагдаж буй тээврийн хэрэгслийг үзлэгт хамруулж, засвар үйлчилгээг тогтмол хийх	Тээврийн хэрэгслүүд	20ш	ш	0.06	1.2	Хуваарьт үзлэг болон жил бүрийн улсын тээврийн хэрэгслийн үзлэг	<b>MNS 5013:2009</b> <b>MNS 5011:2020.</b> Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг хийх заавар. Ерөнхий шаардлага
<b>Хөрсөн бүрхэвч (газрын гадарга)</b>									
4.	Нүүрс ачиж, буулгах, хадгалах үед хөрсөн бүрхэвч эвдрэлт өртөх	Хөрсний бохирдлыг бууруулахын тулд төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбайд ахуйн болон аюултай хог хаягдлын цэгүүдийг байгуулах	Төслийн талбай	-	-		Хог хаягдлын менежмент төлөвлөгөөнд тусгагдсан	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	<b>MNS 5916-2008</b> “Газар шорооны ажлын үийн үржил шимт хөрс

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая төг ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
5.	Шатах, тослох материал асгарснаар хөрсөн бүрхэвч бохирдох	ШТМ асгарах, алдагдах үед ашиглах хувийн хамгаалах хэрэгсэл, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд байрлуулах	Төслийн талбайд	жилд 1 ш	ш		1.5	Үйл ажиллагааны турш	<i>хуулалт, хадгалалт”,</i> <b>MNS 5914:2008</b> <i>Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт</i>
6.	Хог хаягдлыг ил задгай хаях	Хог хаягдлыг ангилан ялгаж гэрээт байгууллагаар сар бүр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Төслийн талбай орчмын хөрс	сард удаа	удаа	Хог хаягдлын менежмент төлөвлөгөөнд тусгагдсан		Үйл ажиллагааны туршид, сард нэг удаа	<b>MNS 5850-2019,</b> <i>“Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн</i>
7.	Шингэн хаягдал үүсэх	Био нойл байгуулан, хаягдал усыг эрх бүхий байгууллагаар соруулан зөөвөрлүүлж хаях	Ажилчдын кемп	Жилд 2 удаа	удаа		1	Үйл ажиллагааны турш	<b>MNS 0899-2020,</b> <i>“Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага”</i> <b>MNS 0900-2018,</b> <i>“Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн</i>
<b>Усан орчин</b>									
8.		Усыг үр ашигтай хэрэглэх талаар үхүүлг, сурталчилгааг ажилчдад хийх, мэдээллийн хуудсыг зарын самбарт байрлуулах	Ажилчдын байр	-	ш	0.06	0.3	Үйл ажиллагаа турш	<b>MNS 0899-2020,</b> <i>“Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага”</i> <b>MNS 0900-2018,</b> <i>“Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн</i>
9.	Унд ахуйн усны хэрэглээ	Усыг үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах бодлого, зарчим боловсруулж ажиллах	Дорнын хос транс ХХК	1	удаа		ДҮА*	Үйл ажиллагаа турш	<b>MNS 0899-2020,</b> <i>“Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага”</i> <b>MNS 0900-2018,</b> <i>“Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн</i>



№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая төг ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Биологийн олон янз байдал									
10.	Гаалийн хяналтын бүс байгуулах барилга угсралтын ажлын үед ургамлан нөмрөг устах	Хөрс хамгаалах,цөлжилтөөс сэргийлэх хуульд заасны дагуу үйлдвэрийн газрын 10 хувиас доошгүй (1 га) талбайд зохих журмын дагуу мод тарьж, зүлэгжүүлэх, ногоон байгууламж байгуулах	Төслийн талбай	1	га	Ногоон байгууламжийн төлөвлөгөөнд тусгав.		Төслийн үйл ажиллагааны турш	Байгалийн ургамлын тухай хууль Амьтны тухай хууль
11.		Гаалийн хяналтын бүсийн батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчиж талбай ашиглах барилга байгууламж барихыг хориглох	Төслийн талбай	Барилгын ажлын үед	удаа	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	Ургамал хамгааллын тухай хууль <b>MNS 5916:2008</b> “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”,
12.	Ургамлан нөмрөг дэд бүтцийн барилга байгууламжийн доор дарагдах	Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Дорноговь аймгийн БОАЖГ-тай хамтран ажиллах	Бүс нутаг	ш	-		ДҮА*	Үйл ажиллагааны турш	МУ-ын ерөнхийлөгчийн 2021 оны 10-р сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлиг
13.	Гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээ, техникийн хөдөлгөөнөөс зэрлэг амьтад дайжих, хорогдох	Амьтдыг үргээж, ургамлан нөмрөгийг сүйтгэхгүйн тулд төслийн талбайд тогтсон маршрутаар зорчих	Төслийн талбай	-	гүйцэтгэлээр	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	
14.		Гаалийн хяналтын бүс,ажилчдын хотхон зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаар зэрлэг амьтад дайжих, тэдгээрийн амьдрах орчин доройтох тул Компанийн болон гэрээт ажилчдад амьтан	Төслийн талбай	-	удаа	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд тусгав.		Үйл ажиллагааны турш	<b>MNS 5918:2008</b> “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн


№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	арилгах, Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, сая төг ₮	Нийт зардал (1 жил), ₮	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
		хамгаалах, танин мэдэхүйн мэдээлэл, сургалтаар хангах							ерөнхий шаардлага
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний нийт зардал						4,100,000 ₮			

*Тайлбар: ДҮА\*-Дотоод үйл ажиллагаа, ХОЗ\*-Хөрөнгө оруулалтын зардал*

#### 4.4 НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Газрын тухай хуулийн 56.6-д “Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана” гэж тусгасан байдаг.

Энэхүү заалтын дагуу Дорнын хос транс ХХК нь 10 га талбайн 10 хувь буюу 1 га талбайд байгуулах ногоон байгууламжийг мэргэжлийн байгууллагын заавар зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэнэ. 2024 оны БОМТ-ын хүрээнд ногоон байгууламж байгуулах зардалд нийт **1,855,000₮** зарцуулахаар байна.



Зураг 4-1. Ногоон байгууламж байгуулах төлөвлөгдөж буй талбай

Хүснэгт 4-3. Ногоон байгууламжийн төлөвлөгөө

Зорилт	Арга хэмжээ	Цар хэмжээ	Нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Ногоон байгууламж байгуулах	Бордоо хийх	10 ш одой хайлаас	кг	17	Намар	15,000	255,000	-Шар хуайс тарьж ургуулах аргачлал -Мод тарих гарын авлага
	Модыг услах	10 ш шар хуайс	ш	20	Намар	100,000		
	Мод авах	Төслийн талбай	кг	50	Намар	30,000		
	Зүлэгний үр							
<b>Нийт зардал</b>						<b>1,855,000 ₮</b>		

#### 4.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбайд одоогийн байдлаар ил археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй хэдий ч газрын хөрсөнд булагдсан дурсгал олдвор байхыг үгүйсгэхгүй тул үйл ажиллагаа явуулах явцад Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 38.3-т “Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад соёлын биет өв илэрвэл газрын хэвлийг ашиглагч ажлаа зогсоож, энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг хариуцсан байгууллагад нэн даруй мэдэгдэнэ” гэж заасныг баримтлан ажиллана.

#### 4.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорнын хос транс ХХК нь эрсдэлийн үнэлгээгээр тогтоогдсон аюул ослоос урьдчилан сэргийлж, эрсдэлийг бууруулах, арилгах талаарх хууль, дүрэм, журмын дагуу ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны журмыг нэвтрүүлэн ажиллахаар 2024 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 5,200,000 ₮ зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 4-4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.₮	Нийт зардал, сая ₮	Хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	4			6	7	8	9
1.	Байгалийн гамшигт үзэгдэл	Эрх бүхий байгууллагаар Гамшгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэх	Төслийн талбай	1	Үнэлгээ	3,000.0	3	3 жил тутам, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг тодотгохтой уялдуулан тухай бүр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль <b>MNS5566:2020.</b> Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм
2.	Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга самбарыг эзэмшлийн объект тавих.	Төслийн талбай	2	ш	100.0	0.2	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	<b>MNS4244:1994.</b>
3.		Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах.	Төслийн талбай	2	Галын иж бүрдэл	1,000.0	2	Үйл ажиллагааны турш	Хөдөлмөр хамгааллын систем Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага
4.	Аюулгүй ажиллагаа алдагдах	Анхны тусламжийн эмийн сан байршуулах, улирал тутамд шалгаж, шинэчилж байх	Ажилчдын кемп	2	Багц	100.0	0.2	Үйл ажиллагааны турш	<b>MNS0639:2016.</b> Гал түймэр унтраах, аврах тоног төхөөрөмж, багаж болон тээврийн хэрэгслийн нэр томъёо ба тодорхойлолт
<b>Нийт зардал</b>								<b>5,400,000 ₮</b>	

#### 4.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорнын хос транс ХХК нь 2024 онд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, Хог хаягдал ачиж, тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу сар бүр тээвэрлүүлнэ.

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал, сая төг	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1.		Ангилан ялгалттай хогийн савыг байрлуулах	Төслийн талбай	1	ш	500.0	0.5	Төсөл хэрэгжих эхний жилд	
2.	Энгийн хог хаягдал	Хог хаягдал тээвэрлэх устгах эрх бүхий байгууллага ар тогтмол зөөвөрлүүлэх	Хог хаягдал хадгалах түр цэг	12	удаа	300.0	0.3	Сар бүр	
3.		Төслийн талбайн гадаад орчны 50 м зайд цэвэрлэгээ хийх	Төслийн талбай, гадна 50 м зайд	4	удаа	ДҮА*		Улиралд нэг удаа	Хог хаягдлын тухай хууль Эрүүл ахуйн тухай хууль Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг
4.		Аюултай хог хаягдал түр хадгалах цэг байгуулах, зориулалтын савыг байрлуулан, тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай	1	ш	ДҮА*		Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
5.	Аюултай хог хаягдал	Аюултай хог хаягдал үүссэн тохиолдолд эрх бүхий мэргэжлийн байгууллага ар тээвэрлүүлэн, устгуулах	Төслийн талбай	-	удаа	ДҮА*		Шаардлагатай тохиолдолд	
<b>Нийт зардал</b>							<b>800,000 ₮</b>		

#### 4.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-ний чухал хэсэг юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмын 1.5-т зааснаар Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.

Гаалийн хяналтын бүс төслийн 2024 оны үйл ажиллагааны явцад Хүснэгт 4-5-д тусгасан орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг доорх хөтөлбөрөөр хэрэгжүүлнэ. Үүнд:

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Дорнын хос транс ХХК нь төслийн үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор агаарын чанар, хөрсний шинжилгээг жилд 1 удаа хийнэ.
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг жилд 1 удаа хийлгэж, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулан дүгнэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг Дорнын хос транс ХХК бүрэн хариуцна.

Хүснэгт 4-5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	
<b>Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр</b>							
1.	<b>Агаарын чанар</b> • Орчны тоосжилт (PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> TSP)	<ul style="list-style-type: none"> <li>Ажилчдын кемп</li> <li>Тээврийн зам дагуу</li> <li>Нүүрсний овоолгын хажууд</li> </ul>	3	Жилд 2 удаа	110,000	1 хэмжилт 110,000 * 3 цэг * 2 удаа = 660,000	<b>MNS.4585:2016.</b> Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	<b>Хөрсөн бүрхэвч</b> • Хими болон физик • Хүнд металл (As, Cd, Cr, Pb, Co, Cu, Mo, Ni, Sn, Sr, V, Zn)	<ul style="list-style-type: none"> <li>Төслийн талбай дотор</li> <li>Ажилчдын кемпийн хажууд</li> <li>Зам, нүүрсний овоолгын хажууд</li> </ul>	3	Жилд 2 удаа	60,000	1 дээж 60,000*3 цэг * 2 удаа =360,000	<b>MNS.5850:2019.</b> Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ <b>MNS.2305:1995.</b> Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх
<b>Хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр</b>							
1.	<b>Агаарын чанар</b> • Орчны тоосжилт (PM <sub>2.5</sub> , PM <sub>10</sub> TSP) • Агаарын температур • Харьцангуй чийг • Агаар бохирдуулагч хий (SO <sub>2</sub> , NO <sub>2</sub> )	<ul style="list-style-type: none"> <li>Ажилчдын кемп</li> <li>Тээврийн зам дагуу</li> <li>Нүүрсний овоолгын хажууд</li> </ul>	3	Жилд 1 удаа	110,000	1 дээж 110,000*3= 330,000	<b>MNS.4585:2016.</b> Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
2.	<b>Дуу чимээ</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ажилчдын кемп</li> <li>Тээврийн зам дагуу</li> <li>Нүүрс буулгаж</li> </ul>	3	Жилд 1 удаа	20,000	20,000* 3 цэг = 60,000	<b>MNS 4585:2016.</b> Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага



№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Цэгийн тоо	Давтамж	Нэгжийн зардал, ₮	Нийт зардал, ₮	Баримтлах эрхзүйн баримт бичиг
		буй талбайд					
3.	<p><b>Хөрсөн бүрхэвч</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хими болон физик</li> <li>Хүнд металл (<i>As, Cd, Cr, Pb, Co, Cu, Mo, Ni, Sn, Sr, V, Zn</i>)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Зам, нүүрсний овоолгын хажууд</li> <li>Төслийн талбай дотор</li> <li>Ажилчдын кемпийн хажууд</li> </ul>	3	Жилд 1 удаа	60,000	1 дээж 60,000*3 цэг =180,000	<p><b>MNS.5850:2019.</b> Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ</p> <p><b>MNS.2305:1995.</b> Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх</p>
4.	<p><b>Ургамлан нөмрөг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Ургамлын зүйлийн бүрдэл</li> <li>Ургамлан нөмрөгийн бүрхэц</li> </ul>	Орчны бохирдолд өртөж болзошгүй цэг болон алслагдсан цэгүүд	-	Жилд 1 удаа		1,000,000₮	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу
5.	<p><b>Амьтны аймаг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Зэрлэг амьтны тархац, нөөцийг үнэлэх зорилгоор шугаман замналын судалгаа хийх</li> <li>Шувуудын судалга, махчин шувуудын үүрний байршлыг тогтоох</li> </ul>	Төслийн талбай болон түүний ойролцоох талбайд (2-3 харууц цэгийг сонгож бүртгэл хийх)	3	Жилд 1 удаа		1,000,000₮	Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу
6.	<b>Замын зардал</b>		1			1,000,000₮	
	<b>Нийт зардал</b>					<b>4,590,000 ₮</b>	

#### 4.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Дорнын хос транс ХХК-ийн 2024 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөг Хүснэгт 4-б-д тусгав.

Хүснэгт 4-б. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв сая ₮	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2024 он			
			VII	IX	XII	
	1	2	3	4	5	6
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	ДҮА*	+			
2.	Гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шүүрхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар сургалтыг ХАБ-ын мэргэжилтэн хариуцан жилд 1 удаа зохион байгуулах	ДҮА*			+	Удирдлага болон хариуцсан мэргэжилтэн
3.	Гаалийн хяналтын бүсийн батлагдсан ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл, ашиглах газрын хэмжээг зөрчиж талбай ашиглах барилга байгууламж барихыг хориглох	ДҮА*	+			
4.	Амьтдыг үргээж, ургамлан нөмрөгийг сүйтгэхгүйн тулд төслийн талбайд тогтсон маршрутаар зорчих, маршрутыг зохион байгуулах	ДҮА*		+		
5.	Байгаль орчныг хамгаалах чиглэлээр Гаалийн хяналтын бүс, ажилчдын хотхон зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаагаар зэрлэг амьтад дайжих, тэдгээрийн амьдрах орчин доройтох тул Компанийн болон гэрээт ажилчдад амьтан хамгаалах, танин мэдэхүйн мэдээлэл, сургалтаар хангах	Төслийн талбай	-	удаа	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөнд тусгав.	Үйл ажиллагааны турш
<b>Нийт зардал</b>					<b>1,000,000 ₮</b>	

Тайлбар: ДҮА\* -Дотоод үйл ажиллагаа

#### 4.10 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, батлагдсан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөг бууруулах, арилгах арга хэмжээний зөвлөмж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үндэслэн жил бүрийн 12 дугаар сард багтаан дараа оны тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна. БОМТ-г боловсруулж, БОАЖЯ-нд батлуулахаар хүргүүлж, батлагдсаны дараа тухайн жилийн БОМТ-г ханган биелүүлж, түүний үр дүнг тусгасан биелэлтийн тайланг тухайн оны 11 дүгээр сарын 01-ний дотор Дорноговь аймгийн БОАЖГ-т хүргүүлнэ.

Хүснэгт 4-7. БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1.	Дорноговь аймгийн, Хатанбулаг сумын, 3-р багийн Иргэдийн Нийтийн хуралд	БОМТ-ний хүрээнд гүйцэтгэсэн ажлын хураангуй	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн хураангуй танилцуулга	Тухайн жилд			Дорноговь аймагт, Замын-Үүд сумд, 3-р багт
2.	Дорноговь аймгийн байгаль орчны газар		Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	11-р сарын 01-ний дотор	Үйл ажиллагааны зардалд тусгав	Байгаль орчны хэлтэс	Дорноговь аймаг
3.	Байгаль Орчин, Аялал Жуулчлалын яам	Тайлагнах эх хувь албан бичгийн хамт					Улаанбаатар хот

## ДҮГНЭЛТ

Дорнын хос транс ХХК-ийн Гаалийн хяналтын бүс төслийн 2024 оны БОМТ-г боловсруулан дараах дүгнэлтийг хийж байна.

- Гаалийн хяналтын бүс төслийн 2024 оны БОМТ-ний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд 4,100,000₮, ногоон байгууламжийн төлөвлөгөөнд 1,855,000₮, осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд 5,400,000₮, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд 800,000₮, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт 4,590,000₮, удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 1,000,000₮ тус тус төсөвлөв.
- Дорнын хос транс ХХК нь 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд **17,745,000** төгрөг зарцуулан 40 ажил хийж гүйцэтгэхээр байна.